



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/126

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх "10, 11-р байрны гадна фасадны ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	М.Цогзолмаа	- ТЗУХ-ийн дарга
Гишүүд:	Э.Хөхөөхүү	- Иргэний төлөөлөл
	Н.Сүхбаатар	- СТСХ-ийн ахлах мэргэжилтэн
	Т.Эрдэнэбаяр	- ГХБХБГ-ын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Т.Асралт	- ОНӨГ-ын ХАА хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /М.Цогзолмаа/-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Т.Асралт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ



0209430